



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Галуут сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БНА-2022/47/НА-СТА-ТШЗ

Баянхонгор
2022 он

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цээням

Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn

Аудитор: Б.Нарангэрэл

Утас: 99009293 Цахим хаяг: Narangerelb@audit.gov.mn

Цахим хуудас: www.audit.mn

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
3. Аудитын тайлан	11
3.1 Ерөнхий зүйл	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	13
3.8 Аудитын гол асуудал	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
4. Аудитын илрүүлэлт	16
4.1 Төлбөрийн акт	16
4.2 Зөвлөмж	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.Аудитын санал дүгнэлт

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр /			
Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	18,397,631.00	116,029,194.42
33	АВЛАГА	339,101.00	197,764.42
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	53,175.00	136,642.42
33500	Бусад авлага	285,926.00	61,122.00
33510	Байгууллагаас авах авлага	285,926.00	61,122.00
35	БАРАА МАТЕРИАЛ	18,058,530.00	115,831,430.00
35400	Хангамжийн материал	18,058,530.00	105,831,430.00
35410	Бичиг хэргийн материал	855,725.00	2,665,725.00
35420	Аж ахуйн материал	7,621,805.00	10,142,205.00
35430	Сэлбэг хэрэгсэл	21,000.00	21,000.00
35470	Бусад хангамжийн материал	9,560,000.00	93,002,500.00
35600	Мал амьтад	0	10,000,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,719,317,061.79	3,483,995,006.16
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,719,317,061.79	3,483,995,006.16
39200	Биет хөрөнгө	1,699,509,061.79	3,464,187,006.16
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,004,255,344.78	2,013,044,426.78
39202	Хуримтлагдсан элэгдэл	-431,783,763.48	-519,277,228.20
39203	Авто-тээврийн хэрэгсэл	137,204,800.00	137,204,800.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-99,198,689.40	-118,925,344.65
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	177,576,363.00	180,459,407.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-133,868,236.73	-133,105,521.04
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	53,067,328.00	53,720,158.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-40,145,544.61	-39,011,333.04
39209	Зам, гүүрийн байгууламж	0	1,775,753,809.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	94,629,784.70	160,851,538.70
39215	Хуримтлагдсан элэгдэл	-62,228,324.47	-46,527,706.39
39300	Биет бус хөрөнгө	19,808,000.00	19,808,000.00
39301	Програм хангамж	539,000.00	539,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-539,000.00	-539,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	19,808,000.00	19,808,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,737,714,692.79	3,600,024,200.58
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	100,762.00	0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	100,762.00	0
41300	Өглөг	100,762.00	0
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	100,762.00	0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,737,613,930.79	3,600,024,200.58
51	Засгийн газрын хувь оролцоо	1,737,613,930.79	3,600,024,200.58
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,278,420,986.00	1,278,420,986.00
51200	Хуримтлагдсан үр дүн	250,221,791.90	2,113,101,281.69
51210	Өмнөх үеийн үр дүн	286,762,020.68	250,691,011.90
51220	Тайлант үеийн үр дүн	-36,540,228.78	1,862,410,269.79
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	208,971,152.89	208,501,932.89
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,737,714,692.79	3,600,024,200.58

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/ төгрөгөөр /			
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	563,746,573.00	2,399,052,006.51
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	91,735,520.00	1,975,611,320.51
120	Нийтлэг татварын бус орлого	91,735,520.00	1,975,611,320.51
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	91,735,520.00	1,016,429.51
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	1,016,429.51
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	90,735,520.00	0
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	0	1,881,152,391.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	0	93,442,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	472,011,053.00	423,440,686.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	15,187,253.00	14,531,386.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,687,253.00	12,531,386.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,500,000.00	2,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	456,823,800.00	408,909,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	456,823,800.00	408,909,300.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	582,384,181.69	536,641,736.72
21	УРСГАЛ ЗАРДАЛ	582,384,181.69	536,641,736.72
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	514,658,315.62	525,027,474.73
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	246,798,509.00	241,267,889.00
210101	Үндсэн цалин	207,541,541.00	203,723,366.84
210102	Нэмэгдэл	39,256,968.00	37,544,522.16
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,749,051.93	31,350,227.71
210201	Тэтгэврийн даатгал	20,893,966.00	24,439,769.88
210202	Тэтгэмжийн даатгал	2,281,585.00	1,772,253.94
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,439,049.00	1,414,484.06
210204	Ажилгүйдлийн даатгал	436,630.00	341,771.72
210205	Эрүүл мэндийн даатгал	5,697,821.93	3,381,948.11
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,746,300.00	22,424,472.14
210301	Гэрэл, цахилгаан	6,141,900.00	5,487,372.14
210302	Түлш, халаалт	16,604,400.00	16,937,100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	36,800,228.00	40,533,349.00
210401	Бичиг хэрэг	5,135,400.00	5,657,000.00
210402	Тээвэр, шатахуун	26,529,356.00	26,773,280.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,150,472.00	3,288,249.00
210404	Ном, хэвлэл	2,025,000.00	64,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	360,000.00	4,140,820.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	600,000.00	610,000.00
2105	Нормативт зардал	380,000.00	3,746,900.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	380,000.00	3,746,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,676,817.00	3,383,850.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,221,917.00	0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0	100,000.00
210604	Урсгал засвар	2,454,900.00	3,283,850.00
2107	Томилолт, зочны зардал	8,055,000.00	8,208,500.00
210702	Дотоод албан томилолт	6,770,000.00	7,082,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	1,285,000.00	1,126,500.00

Галуут сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	30,774,539.00	17,931,010.25
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	26,428,150.00	15,429,920.25
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	500,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	527,000.00	253,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	60,000.00	88,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,659,389.00	1,659,890.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	800,000.00	0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	133,677,870.69	156,181,276.63
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,535,400.00	21,168,830.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0	135,012,446.63
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	120,142,470.69	0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	67,725,866.07	11,614,261.99
2132	Бусад урсгал шилжүүлэг	53,817,570.00	1,370,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0	320,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	48,622,070.00	0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,195,500.00	1,050,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	13,908,296.07	10,244,261.99
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	13,908,296.07	7,879,881.99
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	0	2,364,380.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-18,637,608.69	1,862,410,269.79
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	17,902,620.09	0
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	17,902,620.09	0
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-36,540,228.78	1,862,410,269.79

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ төгрөгөөр /			
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	473,011,053.00	424,457,115.51
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,000,000.00	1,016,429.51
120	Нийтлэг татварын бус орлого	1,000,000.00	1,016,429.51
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,000,000.00	1,016,429.51
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	1,016,429.51
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	472,011,053.00	423,440,686.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	15,187,253.00	14,531,386.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,687,253.00	12,531,386.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,500,000.00	2,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	456,823,800.00	408,909,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	456,823,800.00	408,909,300.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	457,414,053.00	405,919,115.51
21	УРСГАЛ ЗАРДАЛ	457,414,053.00	405,919,115.51
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	389,688,186.93	394,074,853.52
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	244,413,573.93	241,341,980.99
210101	Үндсэн цалин	202,605,854.93	206,957,346.15
210102	Нэмэгдэл	41,807,719.00	34,384,634.84

Галуут сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,357,729.00	31,246,083.39
210201	Тэтгэврийн даатгал	23,582,503.00	21,643,751.25
210202	Тэтгэмжийн даатгал	2,403,890.00	2,367,604.35
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,871,144.00	1,870,729.11
210204	Ажилгүйдлийн даатгал	529,161.00	468,184.72
210205	Эрүүл мэндийн даатгал	4,971,031.00	4,895,813.96
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,781,150.00	22,485,594.14
210301	Гэрэл, цахилгаан	6,151,750.00	5,548,494.14
210302	Түлш, халаалт	16,629,400.00	16,937,100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	31,230,500.00	44,938,679.00
210401	Бичиг хэрэг	4,813,500.00	7,101,000.00
210402	Тээвэр, шатахуун	22,075,000.00	27,358,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,382,000.00	2,461,569.00
210404	Ном, хэвлэл	2,000,000.00	300,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	360,000.00	6,617,210.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	600,000.00	1,100,000.00
2105	Нормативт зардал	977,000.00	3,800,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	977,000.00	3,800,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,657,900.00	3,685,250.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,203,000.00	0
210602	Тавилга	0	1,400.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0	300,000.00
210604	Урсгал засвар	2,454,900.00	3,383,850.00
2107	Томилолт, зочны зардал	8,055,000.00	8,208,500.00
210702	Дотоод албан томилолт	6,770,000.00	7,082,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	1,285,000.00	1,126,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	28,397,184.00	16,522,776.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	24,013,023.00	12,715,006.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	500,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	527,000.00	253,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	60,000.00	88,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,497,161.00	2,966,570.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,818,150.00	21,845,990.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,818,150.00	21,845,990.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	67,725,866.07	11,844,261.99
2132	Бусад урсгал шилжүүлэг	53,817,570.00	1,600,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	48,622,070.00	0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,195,500.00	1,600,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	13,908,296.07	10,244,261.99
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	13,908,296.07	7,879,881.99
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	0	2,364,380.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	15,597,000.00	18,538,000.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	15,597,000.00	18,538,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	15,597,000.00	18,538,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	15,597,000.00	18,538,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	15,597,000.00	18,538,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-15,597,000.00	-18,538,000.00

Галуут сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,278,420,986.00	216,657,826.54	276,161,054.49	1,771,239,867.03
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	10,600,966.19	10,600,966.19
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,278,420,986.00	216,657,826.54	286,762,020.68	1,781,840,833.22
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	-7,686,673.65	0	-7,686,673.65
9	Тайлант үеийн үр дүн	0	0	-36,540,228.78	-36,540,228.78
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,278,420,986.00	208,971,152.89	250,221,791.90	1,737,613,930.79
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,278,420,986.00	208,971,152.89	250,221,791.90	1,737,613,930.79
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	469,220.00	469,220.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,278,420,986.00	208,971,152.89	250,691,011.90	1,738,083,150.79
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	-469,220.00	0	-469,220.00
19	Тайлант үеийн үр дүн	0	0	1,862,410,269.79	1,862,410,269.79
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	1,278,420,986.00	208,501,932.89	2,113,101,281.69	3,600,024,200.58

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	427,249,200.00	401,939,918.01	25,309,281.99	94.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	427,249,200.00	401,939,918.01	25,309,281.99	94.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	425,649,200.00	400,339,918.01	25,309,281.99	94.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	253,086,500.00	241,341,980.99	11,744,519.01	95.4
210101	Үндсэн цалин	212,780,200.00	206,957,346.15	5,822,853.85	97.3
210102	Нэмэгдэл	40,306,300.00	34,384,634.84	5,921,665.16	85.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,301,600.00	31,140,153.88	3,161,446.12	90.8
210201	Тэтгэврийн даатгал	24,138,100.00	21,537,821.74	2,600,278.26	89.2
210202	Тэтгэмжийн даатгал	2,540,900.00	2,367,604.35	173,295.65	93.2
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,032,700.00	1,870,729.11	161,970.89	92.0
210204	Ажилгүйдлийн даатгал	508,100.00	468,184.72	39,915.28	92.1
210205	Эрүүл мэндийн даатгал	5,081,800.00	4,895,813.96	185,986.04	96.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,179,100.00	22,485,594.14	693,505.86	97.0
210301	Гэрэл, цахилгаан	6,242,000.00	5,548,494.14	693,505.86	88.9
210302	Түлш, халаалт	16,937,100.00	16,937,100.00	0.00	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	47,019,700.00	44,938,679.00	2,081,021.00	95.6
210401	Бичиг хэрэг	7,110,500.00	7,101,000.00	9,500.00	99.9
210402	Тээвэр, шатахуун	27,359,200.00	27,358,900.00	300.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,790,000.00	2,461,569.00	328,431.00	88.2
210404	Ном, хэвлэл	300,000.00	300,000.00	0.00	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	8,360,000.00	6,617,210.00	1,742,790.00	79.2
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,100,000.00	1,100,000.00	0.00	100.0
2105	Нормативт зардал	3,800,000.00	3,800,000.00	0.00	100.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,800,000.00	3,800,000.00	0.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	21,853,100.00	21,850,250.00	2,850.00	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	11,168,000.00	11,166,900.00	1,100.00	100.0
210602	Тавилга	7,000,000.00	6,999,500.00	500.00	100.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	300,000.00	300,000.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	3,385,100.00	3,383,850.00	1,250.00	100.0
2107	Томиллолт, зочны зардал	10,658,200.00	8,208,500.00	2,449,700.00	77.0
210702	Дотоод албан томилолт	8,658,200.00	7,082,000.00	1,576,200.00	81.8
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	2,000,000.00	1,126,500.00	873,500.00	56.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,251,000.00	4,355,770.00	895,230.00	83.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	600,000.00	548,000.00	52,000.00	91.3
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	500,000.00	0.00	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	327,000.00	253,200.00	73,800.00	77.4
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	260,000.00	88,000.00	172,000.00	33.8
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,564,000.00	2,966,570.00	597,430.00	83.2

Галуут сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	26,500,000.00	22,218,990.00	4,281,010.00	83.8
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	26,500,000.00	22,218,990.00	4,281,010.00	83.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,600,000.00	1,600,000.00	0.00	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,600,000.00	1,600,000.00	0.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,600,000.00	1,600,000.00	0.00	100.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	427,249,200.00	401,939,918.01	25,309,281.99	94.1
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	425,749,200.00	401,029,418.01	24719781.99	94.2
320001	Орон нутгийн төсвөөс	425,749,200.00	401,029,418.01	24719781.99	94.2
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,500,000.00	910,500.00	589,500.00	60.7
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,500,000.00	910,500.00	589,500.00	60.7
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	49	49	0	100.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0	100.0
610001	Төсвийн байгууллага	1	1	0	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	24	24	0	100.0
620001	Удирдах ажилтан	9	9	0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	13	13	0	100.0
620003	Үйлчлэх ажилтан	2	2	0	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	24	24	0	100.0
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	9	9	0	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	7	7	0	100.0
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	8	8	0	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	15,187,253.00	14,531,386.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	15,187,253.00	14,531,386.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	15,187,253.00	12,167,006.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,187,253.00	12,167,006.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,187,253.00	12,167,006.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	2,364,380.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	2,364,380.00
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	-	2,364,380.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	15,187,253.00	14,531,386.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	15,187,253.00	14,531,386.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,687,253.00	12,531,386.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,500,000.00	2,000,000.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	0.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Галуут сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Нарангэрэл гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Галуут сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр ирүүлсэн ба төсвийн зарцуулалтад нэгдүгээр гарын үсгийг дарга Ш.Мөнхбаатар, хоёрдугаар гарын үсгийг нягтлан бодогч Ц.Ариунаа нар зурсан байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Галуут сумын Засаг даргын Тамгын газрын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Монгол Улсын хууль тогтоомж, төрийн албаны зарчим ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлж, ажлын байранд ажил хэрэгч уур амьсгал бүрдүүлэн иргэдэд хүргэх төрийн үйлчилгээний нэр хүнд чанар хүртээмжийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ албан хаагчдын албан тушаалын чиг үүрэг, эрх хэмжээгээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавьж төр иргэний хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулахад оршино.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг ба Галуут сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Галуут сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 541,101.2 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 8,116.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 5,681.6 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзээд, 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцоход гүйцэтгэлийн материаллаг байдал 5,634.7 мянган төгрөг байгаа тул, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Галуут сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,862,309.5 мянган төгрөгөөр буюу 107.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	18,397.6	116,029.2	97,631.6
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	339.1	197.8	(141.3)
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	18,058.5	115,831.4	97,772.9
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,719,317.1	3,483,995.0	1,764,677.9
Үндсэн хөрөнгө	2,487,080.6	4,341,381.1	1,854,300.5
Хуримтлагдсан элэгдэл	(767,763.6)	(857,386.1)	(89,622.6)
Нийт хөрөнгө	1,737,714.7	3,600,024.2	1,862,309.5
Өр төлбөр	100.8	-	(100.8)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,737,613.9	3,600,024.2	1,862,410.3
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,737,714.7	3,600,024.2	1,862,309.5

Авлагын дансны үлдэгдэл 141.3 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны байгууллагаас авах 339.1 мянган төгрөгийг барагдуулж, тайлант онд ажиллагсадтай холбоотой 136.6 мянга, гэрэл цахилгааны 61.1 мянган төгрөгийн авлага үүссэнийг бүртгэсэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 115,831.4 мянган төгрөг болж 97,772.9 мянган төгрөгөөр өссөн нь бичиг хэргийн материал дансны үлдэгдэл 1,810.0 мянга, аж ахуйн материал дансны үлдэгдэл 2,520.4 мянга, бусад хангамжийн материал дансны үлдэгдэл 83,442.5 мянга, мал амьтад дансны үлдэгдэл 10,000.0 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 4,341,381.1 мянган төгрөг болж өмнөх оноос 1,854,300.5 мянган төгрөгөөр өссөн нь 18,538.0 мянган төгрөгийн хөрөнгө төсвийн хөрөнгөөр худалдан авч, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021_10_15-ны өдрийн 115 дугаар тогтоолоор 7,144.4 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, Галуут сумын Засаг даргын 2021.11.15-ний өдрийн А/169 дугаар захирамжаар сумын ОНХС-ийн хөрөнгөөр хийсэн 98,000.0 мянган төгрөгийн хөрөнгө, Галуут сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн 2020.12.12-ны өдрийн 40 дугаар тогтоолоор 11465.0 мянган төгрөгийн хөрөнгө, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021_02_11-ны өдрийн 27 дугаар тогтоолоор 1,755,753.8 мянган төгрөгийн гүүр, Галуут сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн 2021.12.14-ний өдрийн 31 дугаар тогтоолоор 8790.8 мянган төгрөгийн өртөг бүхий Өргөөтийн харзыг хамгаалах хашаа зэргийг үнэ төлбөргүй хүлээн авч бүртгэн, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 43 дугаар тогтоолын дагуу 45,389.9 мянган төгрөгийн хөрөнгө акталж, данснаас хассантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3,600,024.2 мянган төгрөг болж 1,862,410.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 1,862,410.3 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд төсвийн нийт зарлагыг 533,367.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 1 удаа тодотгон 107,201.5 мянган төгрөгөөр бууруулж 426,166.1 мянган төгрөгөөр анх батлагдсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг тодотгон 427,949.2 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөж гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 408,909.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, өөрийн орлогоор 910.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 401,939.9 мянган төгрөгийг зарцуулж 7,879.9 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 404,939.9 мянган төгрөг буюу 94.1 хувьтай байгаа нь цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 14,906.0 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 693.5 мянга, хангамж бараа материалын зардлыг 2,081.0 мянга, томилолт, зочны зардлыг 2,449.7 мянга, бараа үйлчилгээний бусад зардлыг 4,281.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тус байгууллагын 2021 оны санхүүгийн тайлангийн завсрын аудитаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотой дараах алдаа, зөрчил илэрсэн ба тус алдаа, зөрчлүүдийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар арилгаж нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандартын дагуу бүртгэсэн байна. Үүнд:

- Тайлант хугацаанд нэмэлт санхүүжилтийн харилцах дансаар хийгдсэн 2,300.0 мянган төгрөгийн орлогын гүйлгээг нягтлан бодох бүртгэлд бүртгээгүйгээс санхүүгийн программ дахь мөнгөн хөрөнгийн үлдэгдэл зөрүүтэй.
- Тайлант хугацааны төсвийн гүйцэтгэлийн тайланг төсвийн хэлбэлзэлтэй тулгахад Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлсийн зардлын төлөвлөгөөг 200.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлын төлөвлөгөөг 2,000.0 мянга, нийт 2,200.0 мянган төгрөгөөр тус тус зөрүүтэй тусгасан.
- Тайлант хугацааны мөнгөн гүйлгээний журналыг тулгахад 750.0 мянган төгрөгийн 4 гүйлгээг тооцооны дансаар дамжуулаагүй, 700.0 мянган төгрөгийн томилолтын урьдчилгаа, гэрэл цахилгааны авлага 31.3 мянга, интернэт холбооны төлбөр 45.9 мянган төгрөгийг тус тус авлагаар бүртгээгүй, шатахууны өглөг 75.2 мянга, томилолтын өглөг 150.0 мянган төгрөгийн өглөгөөр тусгаагүй.
- Сангийн яамны Э-тайланд шивж баталгаажуулсан 3-р улирлын санхүүгийн байдлын тайланг санхүүгийн программд бүртгэсэн тайлантай тулган шалгахад эцсийн үлдэгдэл 47,724.4 мянган төгрөгөөр зөрүүтэй.
- Санхүүгийн тайланд байгаа эргэлтийн хөрөнгийн үлдэгдлийг эд хариуцагчийн тайлантай тулган шалгахад нярав түлш шатахууны тайланг жолоочийн тооцооны хуудсаар бүрэн гүйцэд гаргаагүй, бичиг хэргийн материал, бусад хангамжийн материал, аж ахуйн материалын тайланг зөрүүтэй гаргаснаас нийт орлого 35,537.9 мянга, зарлага 917.4 мянга, эцсийн үлдэгдэл 34,620.5 төгрөгөөр тус тус зөрүүтэй.
- Тайлант онд нийт 45389.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг актлах шийдвэр гарсны дагуу данснаас хасахдаа дахин үнэлгээний нөөц дансанд бүртгэлтэй 546.4 мянган төгрөгийн хөрөнгийн дансны үнэлгээг санхүүгийн тайланд бууруулж бүртгээгүй.
- Сахилгын шийтгэл ногдуулсан албан хаагчийн цалин, нууцын нэмэгдлийг хасахдаа үндсэн цалин бууруулахгүй бүтэн бодож гарт олгох цалингаас хасаж олгож байгаа нь нийгмийн даатгалд цалинг илүү мэдээлж, мөн түүнд ногдох НДШ, ХХОАТ-ыг дутуу тооцоолсон байна. Мөн 5-р сард 6 албан хаагчаас ХХОАТ 82.7 мянган төгрөгийг суутгаагүй, мөн нийгмийн даатгалын шимтгэл 52.1 мянган төгрөгийг санхүүгийн тайланд зөрүүтэй тусгасан.
- 9-р сарын цалинг олгохдоо нэг ажилтанд 500.0 мянган төгрөгийг илүү олгосон ч авлагаар бүртгээгүй зэрэг зөрчлүүдийг санхүүгийн жилийн эцсийн тайланд зассан байна.

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор П.Амаржаргал санхүүгийн тайлангийн аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 9 зорилтын хүрээнд нийт 65 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж 91.3 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 536,641.7 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 45,742.4 мянган төгрөгөөр буюу 7.9 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, эд хогшил худалдан авах зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал, өмнөх оноос буурсан байгаа бол, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, хангамж бараа материалын зардал, норматив зардал, дотоод албан томилолтын зардал, бараа үйлчилгээний бусад зардал өмнөх оноос нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл"-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тус байгууллага нь 2021 онд нийт 484,252.9 мянган төгрөгийн 151 мэдээлэл мэдээлэхээс 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалт, орлого зарлагын гүйлгээтэй холбоотой 10,688.0 мянган төгрөгийн 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Байгууллагын төсвийн хөрөнгийн зарцуулалтад тогтоолын хэрэгжилтийг шалгахад дараах байдалтай байна. Үүнд:

- 2021 оны төсвийг 426,166.1 мянган төгрөгөөр анх баталсан ба тодотголоор 1,083.1 мянган төгрөг нэмж 425,749.2 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 1,500.0 мянган төгрөгийг төсөвт байгууллагын өөрийн орлогоор санхүүжүүлэхээр баталсан ба гүйцэтгэлээр 401,939.9 мянган төгрөг зарцуулсан байгаа нь батлагдсан төсөвт 5.9 хувийн хэмнэлт гаргасан. Үүнээс цалин, нийгмийн даатгалын шимтгэлээс бусад урсгал зардлын төсвийг 137,778.0 мянган төгрөгөөр анх баталсан ба тодотголоор 2,083.1 мянган төгрөг нэмж 139,861.1 мянган төгрөгөөр баталсан ба гүйцэтгэлээр 129,457.8 мянган төгрөг зарцуулсан байгаа нь батлагдсан төсөвт 5.2 хувийн хэмнэлт гаргасан.

- Бичиг хэргийн зардлыг 7,110.5 мянган төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр 7,101.0 мянган төгрөг зарцуулсан байна.

-Албан томилолтын зардлыг 8,658.2 мянган төгрөгөөр баталж гүйцэтгэлээр 7,082.0 мянган төгрөг зарцуулсан нь батлагдсан төсөвт 18.2 хувийн хэмнэлт гаргасан.

- Байгууллагын байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын төсвийг 42,764.0 мянган төгрөгөөр анх баталсан ба тодотголоор 19,584.8 мянган төгрөг хасаж 23,179.1 мянган төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 22,485.6 мянган төгрөг зарцуулж анх баталсан дүнгээс 20,278.4 мянган төгрөг буюу 47.4 хувь хэмнэсэн.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 8,225.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1,725.5 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 6,500.0 мянган төгрөгийн 4 зөвлөмж өгснийг хэрэгжүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 16,209.1 мянган төгрөгийн 7 алдаа зөрчил илэрснээс 7,911.7 мянган төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулж, 384.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 7,913.4 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 5 зөвлөмж өглөө.

4.1 Залруулга

1. Тус байгууллага нь Галуут сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 31 дугаар тогтоолоор 8790.8 мянган төгрөгийн өртөг бүхий Өргөөтийн харзыг хамгаалах хашааг бүртгэх шийдвэрийг ирүүлсэн ч 879.1 мянган төгрөгөөр бүртгэн 7911.7 мянган төгрөгийн зөрүүтэй илэрхийлснийг санхүүгийн тайланд залруулсан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дахь “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд зөв дүнгээр бүртгэж, залруулсан.

4.2 Төлбөрийн акт

1. Засаг даргын нөөц хөрөнгөөс холбогдох тушаал шийдвэргүйгээр 384.0 мянган төгрөгийн шатахууныг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3 дахь “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5 дахь “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна” Сангийн сайдын 2018 оны 318 дугаар “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 4.3 дахь “Тухай шатны Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч нь төсвийн зардлын тооцоог Санхүү, төсвийн асуудал хариуцсан хэлтэс /тасаг/-ээр хянуулан холбогдох газар, хэлтсээс санал авч

нэгтгэн Засаг даргын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсний үндсэн дээр Засаг даргын захирамж гаргуулна” гэсэн заалтыг тус тус зөрчсөн санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайлангийн завсрын аудитаар 384.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож төлүүлсэн.

4.3 Зөвлөмж

1. Тус байгууллага Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 2021 онд нийт 484,252.9 мянган төгрөгийн 151 мэдээлэл мэдээлэхээс 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалт, орлого зарлагын гүйлгээтэй холбоотой 10,688.0 мянган төгрөгийн 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4 дэх “таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийг 7 хоногийн дотор мэдээлнэ” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулаагүй мэдээллийг нөхөн байршуулж зөрчлийг арилгах, цаашид зөрчлийг давтан гаргахгүй зөвлөмжийг хүргүүлэв.

2. Тус байгууллагын төсвийн гүйцэтгэлийн тайланг тулгахад 2021 оны төсвийг 426,166.1 мянган төгрөгөөр анх баталсан ба тодотголоор 1,083.1 мянган төгрөг нэмж 425,749.2 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 1,500.0 мянган төгрөгийг төсөвт байгууллагын өөрийн орлогоор санхүүжүүлэхээр баталсан ба гүйцэтгэлээр 401,939.9 мянган төгрөг зарцуулсан байгаа нь батлагдсан төсөвт 5.9 хувийн хэмнэлт гаргасан. Мөн Галуут сумын байгалийн үзэсгэлэнт газрын тухай “Монгол орны үзэсгэлэнт байгаль, түүхэн дурсгалт газрууд” төслийн хүрээнд “Титанс пикчерс” ХХК-тай гэрээ байгуулан 2535.0 мянган төгрөгийг ЗД-ын нөөц хөрөнгөөс зарцуулсан байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.8 дахь “байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргах”, 1.7 дахь “хууль тогтоомж, Засгийн газрын албан ёсны шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал кино зэргийг санхүүжүүлэхгүй байх” заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Засгийн газрын Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлж, цаашид дээд газраас өгсөн чиглэлийг баримталж ажиллах.

3. Тайлант хугацаанд гэрэл цахилгааны зардал, шуудан холбооны зардал, ном хэвлэлийн зардал, багаж хэрэгслийн зардал, хөдөлмөр хамгааллын хэрэгслийн зардал, тээврийн хэрэгслийн оношилгооны зардал, мэдээлэл технологи, тавилга эд хогшлын зардлаас нийт 3,861.9 мянган төгрөгийг төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг мөрдөөгүй, зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтыг зөрчсөн Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-тай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “Ангилал”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид зардлын ангилал хооронд гүйлгэн зарцуулдаг байдлыг таслан зогсоож, Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар батлагдсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг мөрдөж ажиллах зөвлөмж өгөв.

4. Тус байгууллагын 2021 оны төсөвт зочид төлөөлөгч хүлээн авах зардалд нийт 1,500.0 мянган төгрөг батлагдаж, 2021 оны 03 дугаар улирлын байдлаар 894.5 мянган төгрөгийг биеийн тамирын арга хэмжээ болон, Майдар эргэх ёслолын арга хэмжээнд зарцуулсан, 10 дугаар сард 232.0 мянган төгрөгийн махны үнэ төлсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтыг зөрчсөн, Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар батлагдсан Төсвийн зарлагын эдийн засгийн ангилалтай нийцэхгүй санхүүгийн тайлангийн “Ангилал”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид зочид төлөөлөгч хүлээн авах зардалд төсвийг төлөвлөж, зориулалт бусаар зарцуулдаг байдлыг таслан зогсоох зөвлөмж өгөв.

5. Нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас хүүхдийн баярын бэлэг авахад зориулж 390.0 мянган төгрөгийг холбогдох тушаал шийдвэрийг гаргаагүй зарцуулсан байна.

Энэ нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь “Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга, Засаг даргын дэргэдэх газар, хэлтэс, албаны дарга эрх хэмжээнийхээ хүрээнд тушаал гаргаж, тогтоосон журмаар үйлдсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1 дэх “нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах” гэсэн заалтуудыг зөрчсөн санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид Хөрөнгө захиран зарцуулах шийдвэр гаргалгүй хөрөнгө зарцуулдаг байдлыг зогсоох зөвлөмж өгөх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудитаар өгсөн зөвлөмжийн бүрэн хэрэгжүүлж биелэлтийг нотлох баримтын хамт 2022 оны 05 дугаар сарын 30-ны дотор ирүүлнэ үү.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Галуут сумын Засаг даргын Тамгын газар	7	16,209.1	1	7,911.7	1	384.0	-	-	5	7913.4

_____оОо_____